



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 50

Эрдэнэт

Гудамж, талбайд нэршил олгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон сууцны 11 дүгээр хороолол, 13 дугаар сургуулийн зүүн урд уулзвараас босоо тэнхлэгийн дагуу “11Б” хэсгийн зүүн хойд өнцөг хүртэлх 538м урт гудамжыг “Аялагчдын”, “Хангайн бүсийн худалдааны төв”-ийн хойд талаар Кувейтийн аюулгүйн тойрог хүртэл 350м урт явган зорчигчын гудамжыг “Худалдааны”, Зэст баг, Эрх чөлөөний өргөн чөлөөнөөс I-21 дүгээр байрны баруун талаар тойрон Залуучуудын гудамж хүртэл 262м урт нуман замыг “Монгол ажилчдын”, Баянцагаан баг, Эрдэнэт-Дарханы А1001 авто замаас “Эрдэнэт хивс” Үйлдвэрийн урд талаар хэвтээ тэнхлэгийн дагуу орон нутгийн чанартай 4 замын уулзвар хүртэл 570м урт гудамжыг “Хивсчдийн” гудамж гэж, Зэст баг, Эрдэнэт хотын анхны хөрс хуулсан бульдозерийн хөшөө байрлах 2280м² талбайг “Бүтээн байгуулагчдын”, Зэст баг, Эрх чөлөөний өргөн чөлөө, Залуучуудын гудамжны уулзварын зүүн хойд талд 15800м² бүхий талбайг “Барилгачидын” талбай гэж тус тус нэрэлсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, тэмдэгжүүлэн хаягжуулах, сурталчилах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Дангаасүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МЯГМАРСҮРЭН

C:\Togtool \-A4 doc

00100080